



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/555

Булган сум

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн
улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2 дэх хэсэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/253 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Алдармөнх (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Гишүүд: Н.Мөнхзаяа (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ж.Ганбат (Аймгийн Музейн боловсролын ажилтан)
З.Мөнхнаран (Аймгийн Музейн бүртгэл, мэдээллийн санч)
Э.Халиун (Аймгийн Музейн эрдэм, шинжилгээний ажилтан)
Б.Гүррагчаа (Аймгийн Музейн сан хөмрөгч)

Нарийн бичгийн дарга: Т.Бэхтөр (Аймгийн Музейн захирал)

2. Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

3. Тооллогын ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн болон цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан, танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Алдармөнх)-д үүрэг болгосугай.

6325010767

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны А/146 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ГҮРЭВ-ОЧИР